Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр суралцагчдын академик сэдэлжүүлэлтийн судалгаа

Д.Рэгзэдмаа[1], Х.Сэр-Од[2], Б.Оюунгоо[3], Д.Цэнд-Аюуш[1]
[1]АШУҮИС, Монгол Анагаах Ухаан Олон Улсын Сургууль
[2]АШУҮИС, НЭМ, Биостатистик, Эпидемиологийн тэнхим
[3]АШУҮИС, Сувилахуйн сургууль
Цахим шуудан: regzedmaa@mnums.edu.mn Утас: 88003050

Түлхүүр үг:
Академик сэдэлжүүлэлт, Уламжлалт анагаах ухаан, Robert J. Vallerand (1992-1993) нарын Академик сэдэлжүүлэлт үнэлгээний шинэчилсан загвар, Анагаах ухааны боловсрол, Үнэлгээ, Асуумж

Товч утга:

Үндэслэл: Уламжлалт анагаах ухаан (УАУ) нь эмчилгээний энгийн ойлголтоос эрчимтэй хөгжсөн ШУ-ны мэдлэг болтлоо төгөлдөржин төлөвшиж, Монгол орны цаг агаарын эрс тэс байдал, нүүдэлчин ард түмний ахуй амьдрал, ёс заншилтай зохицсон, эрдэм мэдлэг, оюуны соёлын томоохон өв болсоор ирсэн. Орчин цагт анагаах ухааны энэхүү их өвөөр мэдлэгжүүлэх, эрдэмжүүлэх, Монголд болон дэлхийд дэлгэрүүлэн хөгжүүлэхэд мэргэжилдээ дур сонирхолтой УАУ-ы мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд академик сэдэл чухал нөлөөтэй.

Зорилго: УАУ-ы их эмч мэргэжлээр суралцагчдын дундах академик сэдэлжүүлэлтийг тодорхойлох.

Арга, аргачлал: Судалгааг агшингийн загвар ашиглаж, мэдээллийг цуглуулахад тоон судалгааны асуумж үнэлгээний аргыг ашиглав. Deci & Ryan нарын 1995 онд боловсруулсан AMS 7 дэд бүлэг нийт 28 асуумжийг төрийн болон хувийн их сургуулиудын нийт 247 оюутан google формоор бөглөв. Академик сэдэлжүүлэлтийн 7 дэд бүлэг болон нийлбэр үнэлгээг асуумжийн суралцагсдын ерөнхий мэдээлэлтэй харьцуулсан. 5, 12, 19, 26-р асуултуудад урвуу /reverse/ эргүүлэлт хийсэн. P утгыг тооцохдоо Mann-Whitney U-test болон Kruskal-Wallis test ашиглан тооцлоо.

Үр дүн: Deci & Ryan (1995) нарын өөрийгөө үнэлэх онолд тулгуурлан бүтээгдсэн академик сэдэлжүүлэлтийн 28 асуулт бүхий үнэлгээний хуудсаар Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр суралцагчдыг үнэлэх боломжтой болох нь тогтоогдлоо. Академик сэдэлжүүлэлт түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлыг харьцуулахад статистик ач холбогдол бүхий ялгаатай үнэлэгдсэн ба цаашид нөлөөлөх хүчин зүйлсэд чиглэсэн ажлыг сайжруулах хэрэгцээтэй байна.

Дүгнэлт: Академик сэдэлжүүлэлт түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлыг харьцуулахад статистик ач холбогдол бүхий ялгаатай үнэлэгдсэн ба цаашид нөлөөлөх хүчин зүйлсэд чиглэсэн ажлыг сайжруулах хэрэгцээтэй байна. УАУ-ы чиглэлээр суралцагчдын сэтгэл ханамж, мэргэжлийн үнэ цэнэ, цаашид олон улсад мэргэжлээрээ тогтвортой ажиллах боловсон хүчин болон бэлтгэгдэх, сурлагын амжилт чанарыг ахиулахад академик сэдэлжүүлэлтийн үнэлгээ нь суралцагчдын дунд тулгарч буй асуудлыг сайжруулахад үр дүнтэй интервенц болох боломжтой.

Үндэслэл: Монголын уламжлалт анагаах ухаан нь өвөг дээдсийн оюун билиг, эрэл хайгуул, дадлага туршлагаас үүсэн бий болж 5000 жилийн хөгжлийн замыг туулан ирэхдээ анагаахын үе үеийн эмч маарамба, мэргэдийн хичээл зүтгэлээр баяжигдан, цаг хугацааны урт шалгуурыг даван, хөгжин цэцэглэх, гандан буурах түмэн нугачааг туулж өнөөгийн бидэнтэй золгосон. Түүхийн энэхүү урт хугацааны туршид олон үеийн эмч, эрдэмтэд өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, ур ухаан, урлаг аргуудыг үүдэн бүтээж чадсан бөгөөд үүнийг

өнөөдөр ч хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэсээр байна.[1,3] Уламжлалт анагаах ухааны боловсрол нь ихэвчлэн гэр бүлийн болон шавилан сургах боловсрол, Мамба дацангийн боловсрол, орчин үеийн сургуулийн боловсрол гэх 3 шат үеийг өнгөрүүлсэн байдаг. 16-р зууны сүүлээс өмнө гэр бүлийн болон шавилан сургах хэлбэрээр боловсрол олгож байсан бол 16-р зууны сүүлээс 20-р зууны дунд үе хүртэл Мамба дацангийн боловсрол дээр тулгуурлан хөгжиж, 20-р зууны дунд үеэс орчин үеийн сургуулийн хэлбэрийн боловсрол голлож ирсэн байна [2]

Суралцагчдын амжилттай суралцахын гол үндэс нь сургуулийн зүгээс оюутнуудаа байнга сэдэлжүүлж, тэднийг урамшуулах, урам зориг өгөх явдал юм. Суралцагчдын бүтээмжийг өндөр түвшинд хүргэх, хичээлээ хийх зөв арга барил, бие даан суралцах, цагаа зөв зохицуулах, сэтгэл ханамжтай болгогч хүч бол “Сэдэлжүүлэлт” юм. Сэдэлжүүлэлтийн ойлголтыг сэтгэл судлалын шинжлэх ухаанд илүү тодорхойлон авч үздэг.[4]

Өөрийгөө тодорхойлох онол self-determination theory (SDT) нь хүний сэдэлжүүлэлтийн тухай ойлголтыг маш ойлгомжтой болгоход томоохон хувь нэмэр оруулсан. Өөрийгөө тодорхойлох онолд self-determination theory (SDT) тулгуурлан академик сэдэлжүүлэлтийн үнэлгээ асуумж бий болсон бөгөөд суралцагчдын академик сэдэлжүүлэлтийг үнэлж сурах арга барилыг тодорхойлоход ашигладаг байна. Академик сэдэлжүүлэлтийн үнэлгээ асуумжийн аргаар өндөр хөгжилтэй барууны орнууд өөрсдийн боловсролын тогтолцоонд амжилттай хэрэгжүүлсэн байдаг.[5] Гэсэн хэдий ч Монгол улсад Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр суралцаж буй суралцагчдын академик сэдэлжүүлэлтийн үнэлгээний монгол хувилбарт илрүүлэг оношилгооны хүчин төгөлдөр найдвартай байдлыг үнэлээгүй, төгсөлтийн өмнөх сургалтад суралцагчдаас асуумж судалгааг авч үнэлгээ дүгнэлт хийгдсэн байдал нь хомс байдаг. Сэдэлжүүлэлт нь суралцагчдын сурах идэвх ба суралцах үйл явцыг дэмжиж өгдөг чухал хөшүүрэг.[6] Академик сэдэлжүүлэлтийн дотоод сэдэлжүүлэлт, гадаад сэдэлжүүлэлт, огт сэдэлгүй зэрэг нь анагаах ухааны боловсролын түвшинд илүү чухал нөлөөлөх 3 хүчин зүйл гэж үздэг. Энэхүү хүчин зүйл нь үр дүнтэй суралцах, бүтээлч байдлыг дэмжих түүнчлэн илүү сайн өөрчлөлтөд хүрэх боломжийг олгодог. Дотоод сэдэлжүүлэлтийг мэдлэг эзэмших, гүйцэтгэлд чиглэсэн, туршлагажих (E, Int, Id) гэсэн хувьсагчаар тодорхойлдог. Дотоод сэдэлжүүлэлт гэдэг нь дотоод сэтгэл хөдлөлийн хөшүүргээр хийгдэж буй үйл ажиллагааг хэлнэ. Үр дүн нь эерэг шагнал эсвэл сөрөг шийтгэл байж болно.[7]

Уламжлалт анагаах арга, ухаан нь эмчилгээний энгийн ойлголтоос эрчимтэй хөгжсөн шинжлэх ухааны мэдлэг болтлоо төгөлдөржин төлөвшиж, Монгол орны цаг агаарын эрс тэс байдал, нүүдэлчин ард түмний ахуй амьдрал ёс заншилтай зохицсон, эрдэм мэдлэг, оюуны соёлын томоохон өв болсон. Орчин цагт анагаах ухааны энэхүү их өвөөр мэдлэгжүүлэх, эрдэмжүүлэх, уламжлалт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, найдвартай болгох, шинэ эм, эмчилгээний шинэ технологи боловсруулах, брэнд бүтээгдэхүүн, бүтээл гаргах цаашлаад Монгол болон Дэлхийд дэлгэрүүлэн хөгжүүлэхэд мэргэжилдээ дур сонирхолтой уламжлалт анагаах ухааны мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд суралцахуйн сэдэл чухал нөлөөтэй гэж үзэж байна.[3]

Их сургуулийн 1-3 дамжаанд шинжлэх ухааны суурь хичээлийг түлхүү үздэг бол 4-6 дамжаанд мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээл давамгай орж өмнөх дамжаанд олж авсан суурь хичээлийг бататгаж оюутнууд их сургуулийн түшиц эмнэлэг, анхан шатны тусламж үйлчилгээ, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, аймаг дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, сувилал, төв эмнэлэг, гэрээт хувийн эмнэлэгт дагалдан эмч, эмнэлзүйн багшийн удирдлаган дор дадлага хийж эмнэлгийн тусламж үйлчилгээ, өвчний түүх хэрхэн хөтлөх, монгол улсад мөрдөгдөж буй стандарт хэмжилзүйтэй танилцах, үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа хандлага, мэдлэг, ур чадварыг эзэмшиж гардан үйлдлээр бодит үзлэг хийж, эмнэлзүйн тохиолдол шийдвэрлэж, мэргэжлийн ур чадвар эзэмшдэг тул I дамжаа, IV дамжааг Уламжлалт анагаах ухааны /УАУ/ хөтөлбөрийн агуулгын шилжилтийн үе гэж үзэж байгаа болно.[8]

Сэдэл буюу мотивацийг байнга судалж байх нь тодорхой нөхцөл байдал бүрд хүнийг үйл ажиллагаанд өдөөн түлхэж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох замаар түүнд удирдлагын тохирох нөлөөллийн хэрэгслийг хэрэглэх боломжийг олгодог. Оюутан бүрийн суралцах арга барил харилцан адилгүй, өөр өөрийн тогтсон арга барилаар хичээллэж, сургалтын ахиц дэвшил гаргадаг. Энэ нь тухайн хүн өөрийгөө хэрхэн сэдэлжүүлж, хичээл хийх урам зоригийг өөртөө бий болгож байгаагаас шууд хамааралтай байдаг. Энэ чиглэлээр хийгдсэн судалгаа Монгол улсад хомс, ялангуяа уламжлалт анагаах ухааны чиглэлээр суралцагчдын дунд хийгдээгүй байгаа нь судалгааны ажил хийх үндэслэл болсон.

Зорилго: Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр суралцагчдын академик сэдэлжүүлэлтийг тодорхойлох.

1. Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын академик сэдэлжүүлэлтийг үнэлэх.
2. Уламжлалт анагаах ухааны сэдэлжүүлэлтэд

нөлөөлөх хүчин зүйлсийг судалж тогтоох.

Арга, аргачлал: Судалгаагхийжгүйцэтгэхдээ аналитик судалгааны агшингийн загвар ашиглаж, мэдээллийг цуглуулахад тоон судалгааны асуумж үнэлгээний аргаар хийж гүйцэтгэсэн. Судалгаанд 5 бүлэг бүхий 142 асуумж үнэлгээг Монгол Улсад Уламжлалт анагаахын чиглэлээр бакалаврын түвшний эмч бэлтгэж байгаа их сургуулиуд болох Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль (цаашид АШУҮИС, МАУОУС), Оточ Манрамба их сургууль, Ач анагаах ухааны их сургууль, “Этүгэн” Их сургуулийн I, IV дамжаанд суралцаж буй нийт 321 суралцагчдаас энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар тооцон 247 оюутан хамруулж судалгааг хийж гүйцэтгэлээ.


УАУ-ны их эмч мэргэжлээр суралцагчдаас академик сэдэлжүүлэлт-Academic motivation /AM-28/, хяналтын хуудас outcome inventory /OI-21/, Олон төлөвт нийгмийн дэмжлэг Multidimensional scale for perceived social support /MSPSS/, Бие хүний хэв шинжийг тодорхойлох асуумж үнэлгээ-Myers–Brigg Type Indicator (MBTI-70) түвшинг тус бүр 1-7 оноо бүхий Ликертийн хэмжүүрээр үнэлсэн. Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн их сургуулиудын суралцагчдаас таниулсан зөвшөөрлийг авсны үндсэн дээр google form болон цаасан хэлбэрээр судалгааг хийж, үр дүнг Prism, SPSS 27 программыг ашиглаж статистик боловсруулалтыг хийлээ. Академик сэдэлжүүлэлтийн 7 домайн болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлыг асуумжийн суралцагсдын ерөнхий мэдээлэлтэй харьцуулсан. 5, 12, 19, 26-р асуултуудад урвуу / reverse/ эргүүлэлт хийсэн. P утгыг тооцохдоо Mann-Whitney U-test болон Kruskal-Wallis test ашиглан тооцов. Бид АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 03 дугаар сарын 17-ны хурлаар судалгааны ажлыг хийх ёс зүйн зөвшөөрөл авч хийж гүйцэтгэв. (Протокол № 2023/3-03)

Үр дүн: 2024 оны 4 сарын байдлаар Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр суралцаж буй нийт 247 оюутныг судалгаанд хамруулсан. Хүйсийн байдлаар авч үзвэл 77.2% нь эмэгтэйчүүд, 22.8% нь эрэгтэйчүүд байв. Төгссөн сургуулиар авч үзвэл 87.3% нь улсын сургууль, 12.7% нь хувийн сургууль төгссөн байв. Бие хүний хэв шинжээр нь авч үзвэл 57.9% нь гадагшаа чиглэсэн, 42.1% нь дотогшоо чиглэсэн байв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	*НИЙТ*	*Ач АУИС*	*Этүгэн АУИС*	*АШУҮИС - МАУОУС*	*Оточ манрамба АУИС*
Хүйс					
Эрэгтэй	45 (22.8%)	3 (11.1%)	15 (24.6%)	18 (22.2%)	9 (32.1%)
Эмэгтэй	152 (77.2%)	24 (88.9%)	46 (75.4%)	63 (77.8%)	19 (67.9%)
Ахлах сургууль					
Улсын сургууль	172 (87.3%)	22 (81.5%)	52 (85.2%)	75 (92.6%)	23 (82.1%)
Хувийн сургууль	25 (12.7%)	5 (18.5%)	9 (14.8%)	6 (7.4%)	5 (17.9%)
Гэр бүлийн гишүүн АУ-ны чиглэлээр ажилладаг эсэх					
Үгүй	120 (60.9%)	13 (48.1%)	35 (57.4%)	57 (70.4%)	15 (53.6%)
Тийм	77 (39.1%)	14 (51.9%)	26 (42.6%)	24 (29.6%)	13 (46.4%)
Голч дүн					
<2	4 (3.6%)	-	4 (20.0%)	-	-
2-3	38 (33.9%)	3 (17.6%)	8 (40.0%)	25 (39.7%)	2 (16.7%)
>3	70 (62.5%)	14 (82.4%)	8 (40.0%)	38 (60.3%)	10 (83.3%)
Бие хүний хэв шинж					
Гадагшаа чиглэсэн	114 (57.9%)	20 (74.1%)	34 (55.7%)	41 (50.6%)	19 (67.9%)
Дотогшоо чиглэсэн	83 (42.1%)	7 (25.9%)	27 (44.3%)	40 (49.4%)	9 (32.1%)

Академик сэдэлжүүлэлтийг хүйсийн байдал 7 домайн тус бүрээр харьцуулан авч үзэхэд статистик ач холбогдол ажиглагдаагүй. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдийн хувьд дотоод сэдэлжүүлэлт-мэдлэг эзэмших (19.2), дотоод сэдэлжүүлэлт-гүйцэтгэлд чиглэсэн (18.4), дотоод сэдэлжүүлэлт-туршлагажих (17.7), гадаад сэдэлжүүлэлт- бие даасан зохицуулга (18.9), гадаад сэдэлжүүлэлт-дотоод зохицуулга (18.4), гадаад сэдэлжүүлэлт-гадаад зохицуулга (18.1) байсан бол эрэгтэйчүүдийн хувьд огт сэдэлгүй (22.4) буюу тухайн мэргэжлээр цаашид суралцах сэдэлгүй байгаа нь эмэгтэйчүүдийн хувьд харьцуулахад (21.5) ялгаатай байв. (Зураг 1)




Зураг 1. Академик сэдэлжүүлэлтийн үнэлгээ, хүйсээр

Нийт суралцагчдын академик сэдэлжүүлэлтийг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн төгссөн сургуулиар авч үзэхэд хувийн хэвшлийн сургууль төгссөн оюутнуудын академик сэдэлжүүлэлт (141.4±35.6) төрийн өмчийн сургууль сургууль төгссөн оюутнуудын академик сэдэлжүүлэлт (129.4±37.1) харьцуулахад илүү сурах сэдэл өндөр байгаа нь ажиглагдаж байв. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Академик сэдэлжүүлэлт ба ЕБС-ийн хэлбэр

Үзүүэлэлт Дундаж ± С.Хаз	***Төрийн өмч Дундаж ± С.Хаз***	***Хувийн хэвшил***	***Р-утга***
Дотоод сэдэлжүүлэл-мэдлэг эзэмших	18.6±7.0	**20.5±6.8**	0.175
Дотоод сэдэлжүүлэл-гүйцэтгэлд чиглэсэн	17.8±7.0	**20.0±6.9**	0.126
Дотоод сэдэлжүүлэл-туршлагажих	17.3±6.6	**19.6±7.0**	0.107
Гадаад сэдэлжүүлэл-бие даасан зохицуулга	18.5±6.8	**20.8±6.0**	0.112
Гадаад сэдэлжүүлэл-дотоод зохицуулга	17.8±7.0	**19.7±6.9**	0.199
Гадаад сэдэлжүүлэл-гадаад зохицуулга	17.5±6.2	**20.0±5.8**	0.083
Огт сэдэлгүй	21.8±6.7	**20.8±7.3**	0.515
Академик сэдэлжүүлэлт-28	129.4±37.1	**141.4±35.6**	0.097

Уламжлалт анагаахын эмч мэргэжлээр суралцагчдын гэр бүлийн байдлаар авч үзвэл гэр бүлийн гишүүн анагаах ухааны чиглэлээр ажилладаг эсэх асуумжинд тийм гэж хариулсан оюутнуудын дотоод сэдэлжүүлэлт-мэдлэг эзэмших (19.8), дотоод сэдэлжүүлэлт-гүйцэтгэлд чиглэсэн (18.9), дотоод сэдэлжүүлэлт-туршлагажих (18.5), гадаад сэдэлжүүлэлт- бие даасан зохицуулга (19.7), гадаад сэдэлжүүлэлт-дотоод зохицуулга (18.8), гадаад сэдэлжүүлэлт-гадаад зохицуулга (18.6), огт сэдэлгүй (21.8) байсан бол үгүй гэж хариулсан оюутнуудын дотоод сэдэлжүүлэлт-мэдлэг эзэмших (18.2), дотоод сэдэлжүүлэлт-гүйцэтгэлд чиглэсэн (17.6), дотоод сэдэлжүүлэлт-туршлагажих (17), гадаад сэдэлжүүлэлт- бие даасан зохицуулга (18.3), гадаад сэдэлжүүлэлт-дотоод зохицуулга (17.6), гадаад сэдэлжүүлэлт-гадаад зохицуулга (17.3), огт сэдэлгүй (21.6) байгаа нь гэр бүлийн гишүүдээс анагаах ухааны чиглэлээр ажилладаг суралцагчдын академик сэдэлжүүлэл, гэр бүлийн гишүүн анагаах ухааны чиглэлээр ажилладаггүй суралцагчидтай харьцуулахад бага зэрэг илүү байгаа нь харагдаж байв. (Зураг 2)



Зураг 2. Гэр бүлийн гишүүн АУ-ны чиглэлээр ажилладаг эсэхийг судалсан дүн

Нийт суралцагчдыг голч дүнгээр харьцуулан авч үзэхэд голч дүн 3-4 байх нь суралцах сэдэл, идэвх санаачлагыг нэмэгдүүлж байв. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Уламжлалт анагаахын их эмч мэргэжлээр суралцагчдын голч дүн


Голч дүн	**<2**	**2-3**	**3-4**	***P-утга***
	Дундаж ± С.Хаз	***Дундаж ± С.Хаз***	***Дундаж ± С.Хаз***	
Дотоод сэдэлжүүлэл-мэдлэг эзэмших	18.0±3.7	17.8±4.2	18.5±4.1	0.500
Дотоод сэдэлжүүлэл-гүйцэтгэлд чиглэсэн	17.0±8.7	17.0±7.3	19.0±6.6	0.332
Дотоод сэдэлжүүлэл-туршлагажих	16.8±9.1	17.1±6.8	18.0±6.4	0.733
Гадаад сэдэлжүүлэл-бие даасан зохицуулга	18.8±7.2	18.1±7.2	19.8±6.2	0.452
Гадаад сэдэлжүүлэл-дотоод зохицуулга	13.3±6.0	12.8±5.1	14.4±5.4	0.219
Гадаад сэдэлжүүлэл-гадаад зохицуулга	16.3±9.6	17.6±6.2	19.6±5.6	0.206
Огт сэдэлгүй	18.8±8.2	19.1±4.9	19.5±4.8	0.808
Академик сэдэлжүүлэлт-28	**124.0±37.0**	**123.7±37.5**	**133.5±32.4**	**0.337**

Академик сэдэлжүүлэлт түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлаар авч үзвэл академик сэдэлжүүлэлтийн гадаад болон дотоод сэдэлжүүлэлт гэр бүл, найз нөхөд болон бусдын дэмжлэг сайн суралцагчдын хувьд эерэгээр нөлөөлж, шууд хамааралтай байлаа. Харин айдас түгшүүр, сэтгэл гутрал, саад бэрхшээл, биеших хам шинж нь суралцагчдын сэдэлд сөргөөр нөлөөлж, урвуу хамааралтай байгаа нь регрессийн шинжилгээгээр харагдлаа. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Академик сэдэлжүүлэлт түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарал

	Мэдлэг эзэмших	*Гүйцэтгэлд чиглэсэн*	*Туршлагажих*	*Бие даасан зохицуулга*	*Дотоод зохицуулга*	*Гадаад зохицуулга*	*Огт сэдэлгүй*	*Түгшүүр*	*Сэтгэл гутрал*	*Бэрхшээл*	*Биеших хам шинж*	*Бусдын дэмжлэг*	*Гэр бүлийн гишүүдийн дэмжлэг*	*Найз нөхдийн дэмжлэг*
Мэдлэг эзэмших	1													
Гүйцэтгэлд чиглэсэн	.887**	1												
Туршлагажих	.838**	.801**	1											
Бие даасан зохицуулга	.849**	.823**	.834**	1										
Дотоод зохицуулга	.796**	.833**	.736**	.766**	1									
Гадаад зохицуулга	.691**	.681**	.656**	.728**	.730**	1								
Огт сэдэлгүй	0.023	0.033	-0.052	-0.009	-0.049	-.176*	1							
Түгшүүр	-0.072	-0.104	-.147*	-0.096	-0.008	0.106	-.339**	1						
Сэтгэл гутрал	-.197**	-.222**	-.208**	-.184**	-.190**	0.052	-.441**	.702**	1					
Бэрхшээл	-.178*	-.194**	-.240**	-.179*	-0.086	0.037	-.287**	.760**	.669**	1				
Биеших хам шинж	-0.071	-0.037	-0.068	-0.055	-0.033	0.117	-.164*	.632**	.598**	.555**	1			
Бусдын дэмжлэг	.349**	.308**	.302**	.310**	.352**	.262**	.156*	-.189**	-.288**	-.239**	-.196**	1		
Гэр бүлийн гишүүдийн дэмжлэг	.360**	.361**	.379**	.314**	.364**	.222**	.212**	-.356**	-.427**	-.333**	-.283**	.702**	1	
Найз нөхдийн дэмжлэг	.391**	.376**	.367**	.304**	.382**	.284**	.160*	-.287**	-.327**	-.362**	-.198**	.660**	.684**	1

Бие хүний хэв шинжээр нь авч үзэхэд статистик ач холбогдол бүхий хамааралтай байсан ба академик сэдэлжүүлэлтийн дотоод сэдэлжүүлэлт-туршлагажих (p=0.17), гадаад сэдэлжүүлэлт-дотоод зохицуулга (p= p=0.0001)-д гадагшаа болон дотогшоо чиглэсэн суралцагчдын суралцах сэдэлд хамааралтай байгааг харуулж байна. (Зураг 3)



Зураг 3. Академик сэдэлжүүлэлт, бие хүний хэв шинж хоорондын хамаарал

Хэлцэмж: *Анагаах ухааны их эмч мэргэжлийг сонго*н суралцах сэдэл. Уламжлалт анагаах ухааны их эмч мэргэжлийг сонгон суралцахад нөлөөлж буй суралцахуйн сэдэл, дотоод хөшүүргийн талаар хийгдсэн судалгаа сүүлийн үед түлхүү нэмэгдэж байна. Их британы нэгдсэн вант улсад анагаах ухааны академик сэдэлжүүлэлтийн асуумж үнэлгээнд: дотоод сэдэлжүүлэлт-туршлагажих домайн давамгай байсан суралцагчид үйлчлүүлэгчийг энэрэх, асран нигүүлсэх сэтгэл, бусдад туслах хүсэл эрмэлзэл давамгай байсан бол гадаад сэдэлжүүлэлтийн-бие даасан зохицуулгатай суралцагчдын хувьд эрдэм шинжилгээний ажил, шинэ мэдээллийг эрэл хайгуул хийх сэдэлжүүлэлт илүү өндөр байгаа нь манай судалгааны ажлын үр дүнтэй уялдаж байна.[9]

Академик сэдэлжүүлэлт, сэтгэл зүй тогтвортой байдал хоорондын хамаарал. Deci & Ryan (1995) нарын өөрийгөө тодорхойлох онолд (self-determination theory, SDT) тулгуурлан Robert J. Vallerand (1992-1993) нарын академик сэдэлжүүлэлтийн үнэлгээг 2021 оны 12 дугаар сарын 14-нөөс 31-ны хооронд Украйн улсын, Дебрикан их сургуульд хийгдсэн судалгаанд өөртөө итгэх итгэл, огт сэдэлгүй байх нь сэтгэл зүйн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж амьдарлын сэтгэл ханамж буурч байгаа нь мөн тогтоогдсон байна.[10-20]

Хүйс. Анагаах ухааны чиглэлээр мэргэжлээрээ ажиллах сэдэл, хүйсийн ялгаа, чиг хандлагыг судалж үзэхэд эрэгтэй суралцагчдын хувьд шинжлэх ухаанд дур сонирхолтой, бусдад туслах хүсэл эрмэлзэлтэй, ажил мэргэжлийн цаашдын хэтийн төлөв, тогтвортой байдалд татагдан суралцдаг бол эмэгтэй суралцагчдын хувьд бусдад туслах нинжин сэтгэл, асран энэрэх хүсэл эрмэлзлэл нь түлхүү өндөр байна. Үүнээс дүгнэхэд эмэгтэй суралцагчдын хувьд бусдын төлөөх нинжин сэтгэл нь суралцах сэдэлд хүчтэй хамааралтайгаар нөлөөлдөг бол эрэгтэй суралцагчдын хувьд санхүүгийн тогтвортой байдал суралцах сэдлийг өдөөдөг болох нь мөн бидний судалгааны үр дүнтэй ижил төстэй байна.[21]

Бие хүний хэв шинж анагаах ухааны чиглэлийг сонгон суралцахад чухал нөлөөтэй. Эрүүл мэндийн салбарт бие хүний хэв шинж чанарууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү судалгааны үр дүнгээс харахад эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч мэргэжилтнүүд нь найрсаг харилцаатай, баг хамт олон болон бие даан ажиллах, шийдвэр гаргах чадвар сайтай. Сэтгэл зүйн хувьд тогтвортой, стрессийг даван туулах чадварыг эзэмшсэн байдаг нь мэргэжлийн ур чадвар, тогтвор суурьшилтай, багаар хамтран ажиллах чадвар сайн байгааг илтгэдэг. Дээрх зан чанар нь өөрөө нарийн төвөгтэй, нийгэмд эрэлт хэрэгцээтэй эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч мэргэжилтнүүдийн хувьд амин чухал юм. Гэсэн хэдий ч бие хүний хэв шинж, төрөлх зан чанарын хувьд өөр хоорондоо ялгаатай байдаг. Танин мэдэхүйн бус шинж чанаруудын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх нь нэн чухал бөгөөд суралцагч, эмч, мэргэжилтнүүдийн бие хүний хэв шинжийг тодорхойлж тухайн хүнд тохирсон ачаалал өгөх нь сэтгэл зүйн дарамтыг бууруулдаг байна.[22]

Багшлахуй болон гэр бүлийн дэмжлэг. Их Британи улсад анагаах ухааны их сургуулийн I, II дамжаанд суралцагчдыг хамруулсан чанарын судалгаанд анагаах ухааны боловсрол эзэмших хүсэл эрмэлзэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалсан. Судалгаанаас үзэхэд гэр бүлийн

дэмжлэг сайтай, урам зориг өгдөг гэр бүлтэй суралцагчдын академик сэдэлжүүлэлтэд эерэг нөлөө үзүүлж байсан байна. Харин багш нарын зүгээс ирэх дэмжлэг туслалцаа бага байх нь академик сэдэлжүүлэлтэд урвуу хамааралтайгаар сөрөг нөлөө үзүүлж байсан бөгөөд суралцагчдын урам зоригийг бууруулах нөлөө ажиглагдсан байв.[23]

Багшлахуйн урлаг гэдэг нь хэн нэгэнд аливаа зүйлийг туршиж, алдаж байж сурахаас илүү хурдан сурахад туслах явдал юм. Багшлахуйн урлаг хойшид сэтгэл хангалуун байлгах зорилгоор залуу оюун ухааны байгалийн сониуч занг сэргээх, мэдээлэл түгээх замаар хүнийг өөрчилж, насан туршдаа суралцах хүсэл зорилго, суралцахуйн сэдлийг бадраасаар суралцагчдын бие даан суралцах чадварыг төлөвшүүлж, сэтгэл догдлом ирээдүйн сорилтуудыг удирдан чиглүүлэгч болоход нь туслах явдал юм. Хэцүү зүйлийг амархан болгож чаддаг тэр хүн бол сурган хүмүүжүүлэгч. Залуу багш өөрийн мэдлэгээс илүүг заадаг, дунд насны багш өөрийн мэддэг бүхнийг заадаг, ахмад багш оюутны ойлгож чадах бүхнийг заадаг байна.[24]

Дүгнэлт: Академик сэдэлжүүлэлт түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлыг харьцуулахад статистик ач холбогдол бүхий ялгаатай үнэлэгдсэн ба цаашид нөлөөлөх хүчин зүйлсэд чиглэсэн ажлыг сайжруулах хэрэгцээтэй байна. УАУ-ы чиглэлээр суралцагчдын сэтгэл ханамж, мэргэжлийн үнэ цэнэ, цаашид олон улсад мэргэжлээрээ тогтвортой ажиллах боловсон хүчин болон бэлтгэгдэх, сурлагын амжилт чанарыг ахиулахад академик сэдэлжүүлэлтийн үнэлгээ нь суралцагчдын дунд тулгарч буй асуудлыг сайжруулахад үр дүнтэй интервенц болох боломжтой.

Ном зүй:

1. *L. Bai and M. Fu, “Traditional Mongolian medicine: Past, present and future,” (in eng), Chin Herb Med, vol. 14, no. 3, pp. 343-344, Jul 2022. doi: https://doi.org/10.1016/j.chmed.2022.06.001*
2. *H. X. Yan and Y. Zhen, “[Brief history of education of Mongolian medicine 1947-1977],” (in chi), Zhonghua Yi Shi Za Zhi, vol. 47, no. 2, pp. 107-110, Mar 28 2017. https://doi.org/10.3760/cma.j.issn.0255-7053.2017.02.010*
3. *Эрүүл Мэндийн Яам А, МАУОУС. “Эрүүл мэндийн салбарын 100 жилийн ой” Уламжлалт анагаах ухааны салбар хуралдааны илтгэлийн хураангуйн эмхэтгэл 2021.*
4. *Zhang B, Li YM, Li J, Li Y, Zhang H. The Revision and Validation of the Academic Motivation Scale in China. Journal of Psychoeducational Assessment. 2016/02/01 2015; 34(1):15-27. doi:10.1177/0734282915575909*
5. *De Naeghel J, Keer H, Vansteenkiste M, Rosseel Y. The Relation between Elementary Students’ Recreational and Academic Reading Motivation, Reading Frequency, Engagement, and Comprehension: A Self-Determination Theory Perspective. Journal of Educational Psychology. 11/01 2012; 104:1006. doi:10.1037/a0027800*
6. *D. Ahn, G. Park, K. J. Baek, and S.-I. Chung, “Academic Motivation, Academic Stress, and Perceptions of Academic Performance in Medical Students,” Korean J Med Educ, vol. 19, no. 1, pp. 59-71, 3 2007. https://doi.org/10.3946/kjme.2007.19.1.59*
7. *A. d. A. Cadête Filho, J. M. Peixoto, and E. P. Moura, “Medical students’ academic motivation: an analysis from the perspective of the Theory of Self-Determination,” Revista Brasileira de Educação Médica, vol. 45, 2021. https://doi.org/10.1590/1981-5271v45.2-20200129.ing*
8. *R. M. Ryan and E. L. Deci, “Intrinsic and extrinsic motivation from a self-determination theory perspective: Definitions, theory, practices, and future directions,” Contemporary educational psychology, vol. 61, p. 101860, 2020. https://doi.org/10.1016/j.cedpsych.2020.101860*
9. *I. C. McManus, G. Livingston, and C. Katona, “The attractions of medicine: the generic motivations of medical school applicants in relation to demography, personality and achievement,” BMC Medical Education, vol. 6, pp. 1-15, 2006. doi: https://doi.org/10.1186/1472-6920-6-11*
10. *Black AE, Deci EL. The effects of instructors’ autonomy support and students’ autonomous motivation on learning organic chemistry: a self-determination theory perspective. Sci Ed. 2000;84(6):740–756. In John Wiley & Sons, Inc. doi: 10.1002/1098-237X (200011)84:6<740:AID-SCE4>3.0.CO;2-3 10 B. OLÁH ET AL.*
11. *Burton KD, Lydon JE, D’Alessandro DU, et al. The differential effects of intrinsic and identified motivation on well-being and performance: Prospective, experimental, and implicit approaches to self-determination theory. J Pers Soc Psychol. 2006;91(4):750–762. doi: 10.1037/0022-3514.91.4.750*
12. *Deci EL, Ryan RM. Self-determination theory: A macrotheory of human motivation, development, and health. Canadian Psychology. 2008;49 (3):182–185. doi: 10.1037/a0012801*
13. *Ryan RM, Deci EL. Intrinsic and extrinsic motivations: classic definitions and new directions. Contemporary Educational Psychology. 2000;25 (1):54–67. doi: 10.1006/ceps.1999.1020[35] Van Petegem K, Aelterman A, Van Keer H, et al. The influence of student characteristics and interpersonal teacher behaviour in the classroom on student’s wellbeing. Social Indic Res. 2008;85(2):279–291. doi: 10. 1007/s11205-007-9093-7*
14. *Ratelle CF, Vallerand RJ, Vallerand RJ. The relationship between school-leisure conflict and educational and mental health indexes: a motivational analysis. J Appl Social Psychol. 2005;35(9):1800–1822. doi: 10. 1111/j.1559-1816.2005.tb02196.x*
15. *Salinas-Jiménez MDM, Artés J, Salinas-Jiménez J. Income, motivation, and satisfaction with life: an empirical analysis. Journal Of Happiness Studies. 2010;11(6):779–*

793. doi: 10.1007/s10902-010-9185-y

16. *Martín-Albo J, Núñez JL, Domínguez E, et al. Relationships between intrinsic motivation, physical self-concept and satisfaction with life: A longitudinal study. Journal Of Sports Science. 2012;30(4):337–347. doi: 10.1080/02640414.2011.649776*
17. *Niemiec CP, Lynch MF, Vansteenkiste M, et al. The antecedents and consequences of autonomous self-regulation for college: A self-determination theory perspective on socialization. Journal Of Adolescence. 2006;29 (5):761–775. doi: 10.1016/j.adolescence.2005.11.009*
18. *Jang, H, Kim EJ, Reeve J, et al. Longitudinal test of self-determination theory’s motivation mediation model in a naturally occurring classroom context. J Edu Psych. 2012;104(4):1175–1188. doi: 10.1037/a0028089*
19. *Chen Y, Huang SJ. The relationship between teacher autonomous support and high school students’ self-motivation and basic psychological needs. J Southeast Univ Nat Sci Ed. 2016;41(10):141–145.*
20. *Ryan RM, Deci EL2011A self-determination theory perspective on social, institutional, cultural, and economic supports for autonomy and their importance for well-beingIn: Chirkov, Chirkov, V I., Ryan, R M. Sheldon, K M., editors et al. Human autonomy in cross-cultural context, cross-cultural 45 advancements in positive psychology1stpp. 45–64Springer Science +Business Media B.V10.1007/978-90-481-9667-8_3*
21. *N. G. Kutner and D. R. Brogan, “The decision to enter medicine: Motivations, social support, and discouragements for women,” Psychology of Women Quarterly, vol. 5, no. 2, pp. 341-357, 1980. https://doi.org/10.1111/j.1471- 6402.1980.tb00966.x*
22. *C. Louwen, D. Reidlinger, and N. Milne, “Profiling health professionals’ personality traits, behaviour styles and emotional intelligence: a systematic review,” BMC Medical Education, vol. 23, no. 1, p. 120, 2023/02/18 2023. https://doi.org/10.1186/s12909-023-04003-y*
23. *B. Alcott, “Does teacher encouragement influence students’ educational progress? A propensity-score matching analysis,” Research in Higher Education, vol. 58, no. 7, pp. 773-804, 2017. https://doi.org/10.1007/s11162-017-9446-2*
24. *Kohan et al “A systematic review of faculty development programs based on the Harden teacher’s role framework model” BMC Medical Education (2023) 23:910 https://doi.org/10.1186/s12909-023-04863-4*

Academic motivation in traditional mongolian medical education

Regzedmaa D[1*], Ser-Od Kh[2], Oyungoo B[3], Tsend-Ayush D[1]
[1]Department of Internal Medicine, International School of Mongolian Medicine,
[2]Department of Epidemiology and Biostatistics, School of Public Health,
[3]School of Nursing,
Mongolian National University of Medical Sciences
E-mail: regzedmaa@mnums.edu.mn Tel: +976-88003050

Keywords:
Academic motivation, Traditional Mongolian Medicine, Robert J. Vallerand (1992-1993) Academic motivation self-determination theory model, Medical education, Survey, Assessment

Background: Traditional Mongolian Medicine (TMM) operates on a distinctive and integrated theoretical framework that perceives the human body as a unified entity consisting of both opposing forces and unity. Based on the information gathered through the comprehensive examinations, TMM practitioners conduct a thorough analysis to pinpoint the specific illness or syndrome and provide a definitive diagnosis. The Deci & Ryan (1995) based on Self-determination theory Robert J. Vallerand (1992-1993) was developed academic motivation scale questionnaire to assess students motivation. Intrinsic motivation and a motivation positioned at opposite ends of the spectrum. Intrinsic motivation, being the most autonomous form, was found to be correlated with perceived family support, personal choice to study medicine, and the positive attribute of determination. Conversely, a motivation was associated with factors such as being male, making medicine as a personal choice, and experiencing depression. Intrinsically motivated behaviors are regulated by a type of motivation known as self-determination. Intrinsic motivation is labeled as such because it represents an inherent, personal drive to engage in an activity due to one’s own interest, enjoyment, satisfaction, or recognition of its significance. This inner motivation can be sparked by the excitement of discovering new knowledge, encountering and overcoming challenges, and successfully solving problems.

Aim: To assess student’s academic motivation in Traditional Mongolian medicine

Materials and Methods: Two hundred forty-seven freshman and senior year Traditional medical students completed the Academic Motivation Scale, Outcome Inventory, and Multidimensional Scale for Perceived Social Support, MBTI questionnaire for personality traits. Path analysis was conducted to identify relationships between the variables of interest and each type of motivation, including intrinsic and extrinsic motivation and a motivation. Mann-Whitney U-test and Kruskal-Wallis test were used to calculate P values.

Results: The study found that it is possible to evaluate students of Traditional Mongolian medicine with the 28-question academic motivation scale questionnaire based on Deci & Ryan’s (1995) self-determination theory model. Academic motivation has been assessed with statistically significant differences concerning the factors analysis. To improve academic motivation in students of Traditional Mongolian medicine we need to pay attention to their outcome inventory and perceived social support. The evaluation of academic motivation can be an effective intervention to improve the problems faced by students in the field of Traditional Mongolian medicine. In terms of academic motivation, improving the satisfaction and professional value of the students, to increase academic motivation, the quality of academic achievement and clinical training and supporting mental health is necessary.

Conclusion: Academic motivation has been evaluated with statistically significant differences in relation to the factors influencing it, and there is a need for further improvement of work focusing on influencing factors. The evaluation of academic motivation can be an effective intervention to improve the problems faced by students in the field of UAU, to improve the satisfaction and professional value of the students, and to improve the quality of academic achievement and training as personnel who will work in international professions in the future.